



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

┌ Албан томилолтоор ажиллуулах тухай ┐

Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 301 дүгээр тушаал, Үндэсний статистикийн хорооны Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар бүлгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Булган аймагт "Нүүдэлчин өрхийн судалгаа"-ны программ хангамж турших ажлаар Хүн ам, нийгмийн статистикийн газрын статистикч Д.Даваажаргал, Тамгын газрын Олон нийттэй харилцах хэлтсийн референт З.Нямбаяр нарыг 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 08 дугаар сарын 30-ны өдрүүдэд томилон ажиллуулсугай.

2. Булган аймагт ажиллах томилолтын зардлыг холбогдох төслөөс гаргахыг Тамгын газрын Санхүүгийн хэлтэс /Д.Батсүх/-т зөвшөөрсүгэй.

3. Томилолтын ажлын тайланг ирсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан Тамгын газарт илтгэх хуудсаар танилцуулахыг Хүн ам, нийгмийн статистикийн газрын статистикч /Д.Даваажаргал/, Тамгын газрын Олон нийттэй харилцах хэлтсийн референт /З.Нямбаяр/ нарт даалгасугай.

ДАРГА

Ч.ЦЭВЭГДОРЖ